



ХОТЫН СТАНДАРТ, ХЯНАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 04 сарын 06 өдөр

Дугаар 4/21

Улаанбаатар хот

Стандарт норм, дүрмийн судалгаа
хийх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.15, 67 дугаар зүйлийн 67.5, Стандартчлал техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн 101.1, 101.2, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 21.1.3, Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн зорилт 9.5, Газрын дүрмийн 4 дүгээр зүйлийн 4.1.2; 7 дугаар зүйлийн 7.1.1; 7.1.11 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд тусгагдсан иргэдийн эрүүл, ая тухтай амьдрах, орчны аяулгүй байдлыг хангахад чиглэсэн хотын стандарт, норм дүрмийг олон улсын жишигт нийцүүлэн боловсруулж, мөрдүүлэх ажлыг үе шаттай хэрэгжүүлэх зорилтын хүрээнд 2022 онд хийж гүйцэтгэх стандарт, норм дүрмийн судалгааны жагсаалт, хариуцах нэгжийн хувиарлалтийг хавсралтаар баталсугай.

2.Стандарт, норм дүрмийн судалгааны ажлын даалгавар боловсруулах, Зөвлөх үйлчилгээний мэргэжлийн байгууллагуудтай хамтарч ажиллахыг Хотын хөгжлийн стандартын хэлтэс (Б.Ариунуяа)-т, Худалдаа үйлчилгээний стандартын хэлтэс (Н.Билэгсайхан)-т, Хот нийтийн аж ахуйн стандартын хэлтэс (М.Цогтбилэг)-т, Байгаль орчны стандартын хэлтэс (Д.Өлзийсайхан)-т даалгасугай.

3.Судалгааны ажилд зарцуулах 114,000,000 (Нэг зуун арван дөрвөн сая) төгрөгийг ажил гүйцэтгэх гэрээ, акт, гэрээ дүгнэсэн тэмдэглэлд үндэслэн Бусдаар гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээний зардлаас гүйцэтгэлээр нь тооцож санхүүжүүлэхийг Ахлах нягтлан бодогч (Б.Түмэнжин)-д зөвшөөрсүгэй.

4.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Орлогч дарга (О.Оджаргал)-д үүрэг болгосугай.

ДАРГА



С.ТӨМӨРДУЛАМ

1150500254